



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 710

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлгийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 9 нэрийн, нийт 160,773,000.00 (нэг зуун жаран сая долоон зуун далан гурван мянга) төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 128,618,400.00 (нэг зуун хорин найман сая зургаан зуун арван найман мянга дөрвөн зуу) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Мал эмнэлгийн хүрээлэнгийн захирал Б.Батцэцэгт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ





Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 13 өдрийн
7/0 дугаар тогтоодын хавсралт

МАЛ ЭМНЭЛЭГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГҮЙ, ХӨРӨНГИЙН
АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтан д орсон огноо	Тоо хэмжээ (ширхэ г)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	SH-6000 мотор төл	2011-06-20	1	1,980,000.00	1,980,000.00	1,584,000.00	1,584,000.00	3
2	Био аюулгүйн кабинет 2-р зэрэглэл B2	2011-12-25	1	19,800,000.00	19,800,000.00	15,840,000.00	15,840,000.00	3
3	зориулалтын ширээ, шүүгээ	2011-12-25	2	3,850,000.00	7,700,000.00	3,080,000.00	6,160,000.00	3
4	Ламинар бокс-золзаяа	2017-12-31	1	4,950,000.00	4,950,000.00	3,960,000.00	3,960,000.00	3
5	Полимеразын гинжин урвалын дээж бэлтгэх	2011-12-25	1	6,490,000.00	6,490,000.00	5,192,000.00	5,192,000.00	3
6	Полимеразын гинжин урвалын дээж бэлтгэх т	2011-12-25	1	1,078,000.00	1,078,000.00	862,400.00	862,400.00	3
7	Хөргөх агергат	2011-11-29	1	2,200,000.00	2,200,000.00	1,760,000.00	1,760,000.00	3
8	Хөргөх камер	2011-11-29	1	3,575,000.00	3,575,000.00	2,860,000.00	2,860,000.00	3
9	шингэн азот нэрэнгч	2012-06-27	1	113,000,000.00	113,000,000.00	90,400,000.00	90,400,000.00	3
Нийт дүн					(нэг зуун жаран сая долоон зуун далан гурван мянга)	125,538,400.00	128,618,400.00 (нэг зуун хорин найман сая зургаан зуун арван найман мянга дөрвөн зуу)	